

БАТЛАВ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ
ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ХАМГААЛАЛТЫН
ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө"-д тусгагдсан тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хамрах хүрээ	Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт сонгогдсон байршилд 41 км тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулна. Ойн зурвас байгуулах талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав.
3	Гүйцэтгэх ажил	Сонгогдсон байршлуудад ойн зурваст мод тарих 42100 ширхэг нүх ухах, 2 төрлийн навчит модны 42100 ширхэг суулгацыг тарих ажлыг хийнэ.
	Төсөвт өртөг	147,350,000.00 (нэг зуун дөчин долоон сая гурван зуун тавин мянган) төгрөг
4	Талбайн хэмжээ	41 км
5	Техникийн шаардлага	Хамгаалалтын ойн зурвас байгуулах, арчлах ажлыг гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгац, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг мөрдөж ажиллана.
6	Модны төрөл	Улиас, Хайлаас
7	Хугацаа	Мод тарих 2024.10.15 – 2024.10.25 Дараах жилийн арчилгаа, нөхөн тарилт 2025.05.05 Тендерийн баримт бичигт заагдсан үе шатны ажлын хуваарь болон, гүйцэтгэгчээс ирүүлсэн тодотгосон үе шатны ажлын хуваарьтай уялдан өөрчлөгдөж болно.
8	Ажлын үе шат	Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил нь дараах ажилбаруудаас бүрдэнэ. <ul style="list-style-type: none">- Бэлтгэл ажил- Ойн зурвас байгуулах- Ойн зурвасыг хүлээлгэн өгөх- Зөрчил гологдол арилгах- Тайлан боловсруулах- Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх- Дараа жилийн арчилгаа хамгаалалт
10	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	Бэлтгэл ажил <ul style="list-style-type: none">• Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах;• Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох;• Ойжуулалтын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дарааллын

10		<p>загварыг хавсаргав/</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулах талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцөн сонгох/; • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Суулгацыг хатахаас хамгаалах, Сүүдэрт хадгалах, хадгалах хугацаанд байнга услах, сэрүүн үед битүү машинаар тээвэрлэх; • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах
11	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p>Ойн зурвас байгуулах</p> <ul style="list-style-type: none"> • Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд стандартын шаардлагад нийцсэн навчит төрлийн модны суулгац 42100 ширхгээс доошгүй байхаар тарилт хийнэ. • Ашиглах суулгацыг мод үржүүлгийн газраас ажил гүйцэтгэх талбайд хүргэж өгнө. • Ойжуулалт хийх тарилтын нүхийг мод тус бүрээр ухаж бэлтгэнэ. • Навчит модны суулгацаар ойн зурвас байгуулахаар татсан шуудуунд мод хооронд 1.5 зайтай тогоолох буюу 20-25 см диаметртэй 25-30 см орчим гүн нүх бэлтгэх ба модны нүх ухагч моторт багаж болон трактороор нүхийг ухаж бэлтгэнэ. • Шигүүрэл: Мод хоорондоо 3 метр, эгнээ хооронд 2 метр байхаар тооцож тарилт хийх /Схемийг хавсаргав/ • Мэдээллийн самбар байрлуулна. Самбарын нийт өндөр 3 метрээс багагүй, төмөр хийцтэй байх бөгөөд самбарын хэмжээ 1x1 метрээс багагүй байна Самбарын хөлийн бетон зуурмагаар бэхэлсэн байна. Самбарын мэдээлэлд ойжуулалт хийсэн талбайн зураг, захиалагч болон гүйцэтгэгчийн тухай мэдээлэл, талбайн хэмжээ, тарьсан модны төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллүүдийг заавал оруулсан байна. • Ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэж буй аж ахуйн нэгж нь ажлын явцын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт ирүүлэх.
12		<p>Талбайг хүлээлгэн өгөх</p> <p>Ойн зурвас байгуулсан талбайг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Ойжуулалтын ажлын явцын хяналтыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэг, Ойн газартай гэрээ байгуулсан хөндлөнгийн хяналтын баг тус тус хийж гүйцэтгэнэ. Ойжуулсан талбайг тухай аймаг, суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц, суулгацын амьдралд 75.0 хувиас дээш байвал уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна. Амьдралын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх,</p>

		<p>таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.</p> <table border="1" data-bbox="548 283 1416 558"> <thead> <tr> <th>Ойжуулсан талбай /га/</th> <th>Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь</th> <th>Нэгж жишигталбайн хэмжээ /м²/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1-5</td> <td>5</td> <td>200</td> </tr> <tr> <td>6-10</td> <td>4</td> <td>400</td> </tr> <tr> <td>11-20</td> <td>3</td> <td>400</td> </tr> <tr> <td>21-ээс дээш</td> <td>2</td> <td>400</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> Ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойнаж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна /Маягтыг хавсаргав/. Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана. 	Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишигталбайн хэмжээ /м ² /	1-5	5	200	6-10	4	400	11-20	3	400	21-ээс дээш	2	400
Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишигталбайн хэмжээ /м ² /															
1-5	5	200															
6-10	4	400															
11-20	3	400															
21-ээс дээш	2	400															
13		<p>Зөрчил, гологдол арилгах</p> <ul style="list-style-type: none"> Тарьсан тарьц нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө. Тарьсан тарьц нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. Тарьсан тарьц нь 24,9 хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ. 															
14		<p>Тайлан боловсруулах.</p> <ul style="list-style-type: none"> Ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: <p>а/ “Ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>б/ 1:50000-ны масштабтай Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг;</p> <p>в/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.</p> <p>а. “Ажил гүйцэтгэсэн тайлан”-д:</p> <p>Ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ойжуулалтын ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусадсудалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойжуулсан талбайн</p>															

		<p>ерөнхий байдлын зургийг тайланд хавсаргана.</p> <p>б. “Ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлынхил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр , газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана. Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.</p> <p>Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтын тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ. Ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.</p>
15		<p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <p>Ажлын тайланг Ойн газарт гурван хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгана. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p>
16		<p>Дараа жилийн арчилгаа, хамгаалалт</p> <p>“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу ойжуулсан талбайгаа 1 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно. Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, усалгаа хийх, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээг гэрээ хүчинтэй хугацааны турш хийж гүйцэтгэнэ.</p>
17	Бусад тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Ажлын гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 хүртэл хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хамтран гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд тухайн орон нутгийн мод үржүүлгийн газраас тарьц, суулгац худалдан авах. • Талбайд гарсан хог хаягдлыг цэвэрлэж, хогийн төвлөрсөн цэг рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулна. • Ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын үе шат бүрийг захиалагчид фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. Үүний дараа дараагийн үе шатны ажлыг эхэлнэ.

**ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД
(MNS, ISO9001:2015, UCS)**

Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын гүйцэтгэлд гүйцэтгэгч байгууллага нь дараах стандартуудыг мөрдөж ажиллана.

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа	MNS 4969:2000
2	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо. Шаардлага	MNS OSHAS 18001:2012
3	Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6139:2010
4	Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага”	MNS 6140:2010
5	Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6141:2010
6	Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага	MNS 2418:2011
7	Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх	MNS 6252:2011
8	Мод сөөгний үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага	MNS 6253-1:2011
9	Мод сөөгний үр тарих Ерөнхий шаардлага	MNS 6253-2:2011
10	Мод сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага	MNS 6253:2011
11	Мод сөөгний суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага	MNS 6254:2011
12	Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6255:2011
13	Сөөгөнцөрийн суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6256:2011
14	Улиасны суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6257:2011
15	Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага	MNS 6258-1:2011
16	Мод сөөгний суулгац арчлах	MNS 6258-2:2011
17	Улиасны модоожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага	MNS 1796:2011
18	Бордоо. Доломитын бордоо Техникийн шаардлага	MNS 6662:2017
19	Сөөгний суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага	MNS 6773:2019
20	Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах	MNS 6774:2019
21	Голтборын төрлийн ургамлыг тарих, арчлах. Техникийн шаардлага	MNS 6863: 2020
22	Мод үржүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац ургуулах Техникийн шаардлага	MNS 6864:2020
23	Навчит модны суулгац, техникийн шаардлага	MNS 6141:2020
24	Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага	MNS 5891:2008
25	Фосфорын бордоо	MNS 4305: 1996
26	Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага 11.1 дэх хэсгийн загвар	UCS 1410B:2022
27	Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага	MNS 6088:2010

Үе шатны ажлын хуваарь

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	-	2024-10-15-ны дотор
2	Зурвас байгуулах	12 км	2024-10-20-ны дотор
3	Талбайг хүлээлгэн өгөх	12 км	2024-10-25-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	12 км	2024-11-01-ний дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	-	2024-11-05-ны дотор

6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	-	2024-11-10-ны дотор
7	Арчилгаа, хамгаалалт		2025-12-01-ны дотор

Дархан-уул аймагт хамгаалалтын ойн зурвас байгуулах талбайд таригдах модны тоо

№	Зурвасын урт /км/	Зурвасын өргөн /м/	Эгнээ хоорондын зай /м/	Мод хоорондын зай /м/	Модны төрөл	Нийт модны тоо
1-р талбай	17,2	3	2	3	Улиас	5750
					хайлаас	5750
2-р талбай	1,5	3	2	3	Улиас	1000
3-р талбай	10	12	3	3	Улиас	6600
					хайлаас	6600
4-р талбай	12,3	12	3	3	Улиас	8204
					хайлаас	8204
Нийт						42108






**Дархан-Уул аймагт Хамгаалалтын ойн зурвас
байгуулах 2-р талбай**



Таних тэмдэг

- кабель
- 2-р талбай 1,5 км

Source: Esri, Maxar, Earthstar Geographics, and the GIS User Community



106°00'E



